



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 611

Улаанбаатар хот

Төрийн өмчийг эзэмшүүлэх
гэрээний биелэлтийн мөрөөр
авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ын 3.6, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2018 оны биелэлтийн дүнгээр “Сайн” дүгнэгдсэн төрийн өмчит хуулийн этгээд (ажилтан)-ийг “Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-д заасны дагуу шагнаж, урамшуулахыг зөвшөөрсүгэй.

2.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүнгээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай:

2.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нарт эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн гэрээний биелэлтийн дүнгийн нэгдсэн тайлан бэлтгэж хүргүүлэх;

2.2.Гэрээ дүгнүүлээгүй хавсралтад заасан хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомж, журам, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцох ажлыг зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах;

2.3.Гэрээний биелэлтийн дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж боловсруулж төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх;

2.4.Дор дурдсан ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2020 онд зохион байгуулах улсын үзлэг, тооллогын ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллах:

2.4.1.Автотээврийн үндэсний төвийн тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэлтэй зөрүүтэй, төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил дэх тээврийн хэрэгслийн тоо, төрөл, техникийн тодорхойлолт, өмчлөгч/эзэмшигч/-ийн мэдээллийг нэгтгэн шинэчлэх;

2.4.2.Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтгүй байгаа үл хөдлөх хөрөнгийг тоолж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан танилцуулах;

3.Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нарт өөрийн харьяа болон салбар нэгжүүдэд хуваарилж буй хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг заасан тушаал шийдвэр хүргүүлж байхыг зөвлөсүгэй;

0001199

4.Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал), нягтлан бодогч, Өмч хамгаалах байнгын зөвлөлд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

4.1.Өмчийн харилцааны холбогдох хууль тогтоомж, журам, захиргааны актыг мөрдөж ажиллах;

4.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-д нийцүүлэн байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн журам баталж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.3.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөл нь төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах;

4.4.“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д байгууллагын санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлт, бусад холбогдох мэдээллийг тухай бүр оруулж байх;

4.5.Байгууллагын үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн холбогдох дансанд бүртгэх, ангилал хооронд шилжүүлж залруулах, нэршлийг монгол хэлээр зөв, оновчтой томъёолж байх;

4.6.“Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ыг үйл ажиллагаанд мөрдөж, энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах;

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
6.11 дугаар тогтоолын хавсралт



ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ 2018 ОНЫ БИЕЛЭЛТ ДҮГНҮҮЛЭЭГҮЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг, нийслэл	Хуулийн этгээдийн нэр	Хариуцлагын хэлбэр	Харьяалах дээд байгууллага	Ажлын хэсгийн гишүүд
1	Архангай	Шүүхийн Шинжилгээний Алба	төсөвт	ХЗДХЯ	Г.Дэлгэрмаа, Б.Гэрэлтуяа
2	Увс	Увс аймгийн хөдөө аж ахуйн газар	төсөвт	ХХААХҮЯ	Д.Болортуяа, Б.Сүнжидмаа
3	Ховд	Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	төсөвт	Шадар сайд	Д.Болортуяа, Б.Сүнжидмаа
4	Улаанбаатар	Эрдэнэс Монгол	ХХК	УУХҮЯ	Алтаншагай
5	Улаанбаатар	Стратег судалгааны хүрээлэн	төсөвт	УИХ	Б.Гэрэлтуяа